

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗӨВЛӨЛИЙН 01 ДҮГЭЭР ХУРАЛ**

2020 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 11 цаг 10 минутад эхэлж, мөн өдрийн 16 цаг 00 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын танхимд хийж, нийт 4 цаг 50 минут хуралдав.

дд	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгийн тухай.	1. Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Ерөнхий сайдын захирамж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, албан даалгаврын Ховд аймагт холбогдолтой шийдвэрүүдийн 2020 оны хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг хэлэлцэх явцад гарсан саналыг тусгаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын <a href="http://www.new.unelgee.gov.mn">www.new.unelgee.gov.mn</a> цахим сайтад шивж, баталгаажуулан хугацаанд нь хүргүүлэх, Агентлагын дарга холбогдох мэргэжилтэнүүдийг оны эхэнд тогтоол шийдвэрүүдийн зүйл заалтыг нь зааж өгч оны эцэст дүгнэдэг ажлыг зохион байгуулж Засаг даргын зөвлөлийн хурлаар жилд 3 удаа хэлэлцүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга Д.Ариунбилэг, тус хэлтсийн мэргэжилтэн Ц.Оюунчимэг нарт үүрэг болгов.
2	2019-2020 онд хийгдсэн улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ажилд хяналт шинжилгээ хийсэн тухай.	Нийт 24 барилгын компаниудад албан бичиг хүргүүлж, хэрэв шаардлага биелүүлээгүй тохиолдолд нийтэд цахим сүлжээгээр зарлаж, хар дансанд шилжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Баярсүхэд үүрэг болгов.
3	Асран хамгаалах шаардлагатай, цаашид бие даан амьдрах чадваргүй гэмтэж, бэртсэн зэрлэг амьтан болон тэдгээрийн байгальд орхигдсон үр төлийг асран хамгаалах, зайлшгүй тохиолдолд сэргээн засах	Асран хамгаалах шаардлагатай, цаашид бие даан амьдрах чадваргүй гэмтэж, бэртсэн зэрлэг амьтан болон тэдгээрийн байгальд орхигдсон үр төлийг асран хамгаалах, зайлшгүй тохиолдолд сэргээн засах эмчилгээг хийх, буцаан байгальд тавих ажлыг гүйцэтгэх үүрэг

	эмчилгээг хийх, буцаан байгальд тавих ажлыг гүйцэтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн ажиллах нийтлэг журам хэлэлцүүлэх тухай	бүхий ажлын хэсгийн ажиллах нийтлэг журамыг хэлэлцэх явцад гарсан саналыг тусгаж аймгийн Засаг даргын захирамж гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Баярсүхэд үүрэг болгов.
4	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн тухай	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцэх явцад гарсан саналыг тусгаж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Б.Ганболдод үүрэг болгов.
5	Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө хэлэлцүүлэх тухай.	Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө хэлэлцэх явцад гарсан саналуудыг тусгаж аймгийн Засаг даргын захирамж гаргаж батлуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Б.Ганболдод үүрэг болгов.

#### АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР